Оюутан, төгсөгч, ажил олгогч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бакалаврын хөтөлбөрт өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ

Г.Халиунаа[1], Н.Нансалмаа[1], А.Энхдөлгөөн[2], Э.Эрдэнэчимэг[1], М.Мөнхзаяа[3]

[1]АШУҮИС, НЭМС, Орчны эрүүл мэндийн тэнхим
[2]АШУҮИС, НЭМС, Урьдчилан сэргийлэх анагаах ухааны тэнхим
[3]АШУҮИС, НЭМС, Шүт тэжээл судлалын тэнхим
Цахим шуудан: eph22e002@gt.mnums.edu.mn, Утас: 86007691

Түлхүүр үг:

Төгсөгчдийн ур чадвар
Сургалт
Сэтгэл ханамж
Оюутан
Мэдлэг

Товч утга:

Үндэслэл: Сүүлийн жилүүдэд Монгол Улсад үйлдвэржилт нэмэгдэж ажлын байрны аюултай хүчин зүйлсээс шалтгаалсан осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилготой мэргэжилтний хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. МУ-ын хэмжээнд үйлдвэрийн ослын тохиолдол 2020 оны байдлаар 353 болж өмнөх оноос 0.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнтэй холбоотой ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн хүний нөөцийн асуудал тулгамдаж байна. **Зорилго:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын үйл ажиллагааг суралцагч, төгсөгч, ажил олгогч нарын сэтгэл ханамжийг үнэлэхэд оршино. **Арга, аргачлал:** Судалгаанд АШУҮИС-ийн НЭМС-ийн ХАБЭА-ын бакалаврын хөтөлбөрөөр суралцаж байгаа I-IV-р дамжааны нийт 35 оюутан, 2021 оны ХАБЭА-ын бакалаврын хөтөлбөрөөр суралцаж төгссөн 11 төгсөгч, 12 удирдах албан тушаалтанг хамруулав. Судалгаанд сэтгэл ханамжийг үнэлэх Ликертийн үнэлгээг ашиглав. Судалгааны статистик боловсруулалтыг Microsoft Office Excel программд оруулан, SPSS 22 программд хөрвүүлж нарийвчилсан дүн шинжилгээг хийж гүйцэтгэв. **Үр дүн:** Сургалтын орчин, чанар, сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор ХАБЭА-н мэргэжлээр 1-ээс дээш улирал суралцаж буй 35 (87.5%) буюу 1 дүгээр дамжааны 28.5% (n=10), 2 дугаар дамжааны 11.4% (n=4), 3 дугаар дамжааны 5.7% (n=2), 4 дүгээр дамжааны 54.2% (n=19) суралцаж буй оюутнуудыг хамруулсан. ХАБЭА-н хөтөлбөрт суралцаж буй оюутнуудын сэтгэл ханамжийг судлахад хамгийн их оноо өгсөн **х**ичээлийн хөтөлбөрүүд нь агуулгын хувьд сургалтаар бүрэн эзэмшсэн байдалд 4.21 оноо, багшийн арга зүйд 4.09 оноо, оюутны үнэлгээний арга бодитой, сургалтын орчны байдал сайн (өрөө лаборатори, багаж тоног төхөөрөмж) 3.87 оноо, тухайн хичээл нь дараагийн хичээлийн бэлтгэл болж чадсан эсэхэд 4.19 оноогоор үнэлсэн байна. ХАБЭА-н мэргэжлээр төгсөгч нарын сургалтын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад оюутны сургалтын ачаалал тохиромжтой эсэхэд өгсөн үнэлгээ 4.63 оноо, багш нарын заах арга зүй сайн буюу 4.36 оноо, сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадвар бодитой, шударга үнэлэгдсэн эсэхэд 4.09 оноо, сургалтын зохион байгуулалт сайн буюу 4.09 оноо, сургалт үр дүнтэй сайн гэдэгт 4 оноог тус тус өгөн дунджаас дээгүүр буюу сайнд ойрхон үнэлсэн байна. **Дүгнэлт:** Суралцаж буй оюутан, төгсөгч, ажил олгогч нарын ХАБЭА бакалаврын сургалтын хөтөлбөрт өгсөн сэтгэл ханамжийг тодорхойлсон дүнгээс харахад уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалттай төдийгүй сэтгэл ханамжтайг байгаа нь тодорхойлогдлоо.

Үндэслэл: Дэлхий нийтэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа нь хөдөлмөр эрхэлж буй хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж мэргэжлээс шалгаалах өвчлөл, үйлдвэрийн осол гэмтэлд хүргэх аюултай хүчин зүйлсийг таньж, илрүүлэх, хэмжиж үнэлэх, тэдгээрийг бууруулах, арилгах үндсэнд чиглэдэг. Монгол улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-тай холбоотой хууль тогтоомжуудын шаардлагатай холбоотойгоор ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад

ХАБЭА-н мэргэжилтнүүд чухал үүрэгтэй.[1] Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 27.3-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөрийн эрүүл ахуйч, аюулгүй байдлын ажилтан нь ажлын байран дахь үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйлсэд хяналт тавих, бууруулах замаар ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах" гэж заажээ. Өнөөгийн байдлаар МУ-д мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу ХАБЭА-н мэргэжилтэн дараах мэдлэг, чадамжтай байх шаардлага тавигдаж байна. Үүнд:

- ХАБЭА-н хууль, тогтоомж шаардлагыг мөрдөх
- Байгууллагын хүрээнд мөрдөх ХАБЭА-н бодлого төлөвлөгөө, дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх
- Ажилтнуудад хийх ХАБЭА-н сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах
- Ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг хэмжиж, үнэлэх, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг таньж илрүүлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх
- Үйлдвэрийн ослын эрсдэлийг үнэлэх, үүнээс урьдчилан сэргийлэх
- Мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, үйлдвэрийн ослын тохиолдлыг бүртгэн, мэдээлэх, тандан судлах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- Мэргэжлийн онцлогт тохирсон ажлын хамгаалах хувцас хэрэгслийн зохистой хэрэглээнд хяналт тавих мэдлэг, чадамжтай байх шаардлагатай гэж тодорхойлсон байна.[2]

Манай улсад Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуульд (АШУҮИС) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) мэргэжлээр төгсөж, төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдах, мөн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр хөдөлмөр ба орчны эрүүл мэндийн магистр, докторын түвшинд мэргэжилтэн бэлтгэж байна.[1]

Аж ахуйн нэгж байгууллагууд ХАБЭА-н мэргэжилтэн, ХАБЭА-н менежер, хөдөлмөрийн эрүүл ахуйч нарыг ажиллуулах хэрэгцээтэй байгааг бусад улс орныхтой харьцуулбал:


Манай улсын 100.000 ажилчдад ноогдох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байцаагчийн тоо 8.8 байгаа ба үүнийг Итали, Франц улстай харьцуулахад 2 дахин бага, Нидерланд, Ирланд улстай харьцуулахад 2 дахин их байна. Мөн 50-аас олон ажилтантай байгууллагуудыг 100% ХАБЭА-н ажилтантай гэж тооцвол манай улсад нийт 3522 ХАБЭА-н ажилтнууд, 10.000 ажилчдад 29.5 ХАБЭА-н ажилтан ноогдож байна. Үүнийг АНУ болон Герман улстай харьцуулахад 1 дахин бага, Финланд улстай харьцуулахад 2.4 дахин бага байна. Харин Сингапур улсынхаас 1.5 дахин, Тайланд, Энэтхэг улсын тоотой харьцуулахад 1.9 дахин их тус тус байна.[3]

Үндэсний статистикийн хорооны 2021 оны мэдээгээр МУ-д 50-иас олон ажилтантай 2500 гаруй үйлдвэр байна. Мэргэжлийн хяналтын байгууллагад 95, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд 12, их дээд сургуульд 35, түр сургалтын байгууллагуудад 92, аж ахуйн нэгж зэрэгт нийтдээ 2700 орчим ХАБЭА-н мэргэжилтэн хэрэгцээтэй байх урьдчилсан тооцоо гарч байсан. Цаашид манай улсад аж үйлдвэржилтийн өсөлттэй холбоотойгоор аюултай эрсдэлтэй ажлын байранд ажиллагсдын тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтний хэрэгцээг улам бүр нэмэгдүүлж байна.[4]

Зорилго: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын үйл ажиллагааг суралцагч, төгсөгч, ажил олгогч нарын сэтгэл ханамжийг судлах


Арга, аргачлал: Судалгаанд АШУҮИС-ийн НЭМС-ийн ХАБЭА-ын бакалаврын хөтөлбөрөөр суралцаж байгаа I-IV-р дамжааны нийт 35 оюутан, 2021 оны ХАБЭА-ын бакалаврын хөтөлбөрөөр суралцаж төгссөн 11 төгсөгч, 12 удирдах албан тушаалтанг хамруулан, сэтгэл ханамжийн талаарх хүчин зүйлийг (1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн) 5 онооны Ликертийн хэмжүүрээр үнэлгээг хийв. Судалгааны статистик боловсруулалтыг Microsoft Office Excel программд оруулан, SPSS 22 программд хөрвүүлж нарийвчилсан дүн шинжилгээг хийж гүйцэтгэв. АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн (тэмдэглэлийн дугаар 2022/3-11) хурлаар хэлэлцүүлэн судалгааны дүрэм, журмыг зөрчөөгүй, ёс зүйд нийцсэн тухай судалгааг явуулах зөвшөөрөл авсан.

Үр дүн: Сургалтын орчин, чанар, сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор ХАБЭА-н мэргэжлээр 1-ээс дээш улирал суралцаж буй 35 (87.5%) буюу 1 дүгээр дамжааны 28.5% (n=10), 2 дугаар дамжааны 11.4% (n=4), 3 дугаар дамжааны 5.7%(n=2), 4 дүгээр дамжааны 54.2% (n=19) суралцаж буй оюутнуудыг хамруулсан. ХАБЭА-н сургалтын хөтөлбөрийн сэтгэл ханамжийн 16 асуулт, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг хичээл тус бүр дээр 6 асуулт боловсруулан мэдээллийг цуглуулсан. Хичээлийн хөтөлбөрийн агуулгын хувьд сургалтын агуулгыг бүрэн эзэмшсэн 4.21 оноо, багшийн арга зүй 4.09 оноо, оюутны үнэлгээний арга бодитой, оновчтой, шударга 4.1 оноо, сургалтын орчин сайн (өрөө лаборатори, багаж тоног төхөөрөмж) 3.87 оноо, зохион байгуулалт (хичээлийн хуваарь, ачаалал) 3.98 оноо, тухайн хичээл нь дараагийн хичээлийн бэлтгэл болж чадсан 4.19 оноогоор үнэлэгдэв. (Зураг 1.)



Зураг 1. ХАБЭА-н мэргэжлээр суралцаж буй оюутны сэтгэл ханамж тодорхойлсон дүн

Төгсөгч нараас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар хамгийн бага оноо буюу 3 оноог сургалтад ашиглагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ном, сурах бичиг, гарын авлага, унших материал зэрэгт өгсөн. Хамгийн өндөр оноог багш нарын заах арга зүй, сургалтын ачаалал зэрэгт өгсөн байна. (Зураг 2.)



Зураг 2. ХАБЭА-н мэргэжлээр төгсөгч нарын сургалтын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийг тодорхойлсон дүн

Бид төгсөгч нараас ХАБЭА-н талаар эзэмшсэн ур чадваруудыг үнэлэхэд “ХАБЭА төгсөгчид нь манлайлагч байх”, “Байгууллагын түвшинд хэрэгжүүлж буй үйлдвэрийн ослыг бууруулах, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс сэргийлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах үйл ажиллагаа, ХАБЭА-н менежментийн үр нөлөөг үнэлэгч байх” гэсэн чадварууд сайн хэмээн үнэлэгдэв. (Хүснэгт 1.)

Хүснэгт 1. ХАБЭА-н мэргэжлээр төгссөн төгсөгчдийн ур чадварыг тодорхойлсон дүн

№	Үнэлгээ	1 оноо (%)	2 оноо (%)	3 оноо (%)	4 оноо (%)	5 оноо (%)	Дундаж %
1	Би АШУҮИС төгсөгчийн ХАБЭА хөтөлбөрийн чанарт сэтгэл хангалуун	0 (0%)	0 (0%)	4 (36%)	4 (36%)	3 (27%)	36%
2	Төгсөгчид хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ажилтнаар ажиллах бүрэн чадвартай	0 (0%)	0 (0%)	3 (27%)	5 (45%)	3 (27%)	45%
3	ХАБЭА төгсөгчид сайн судлаач байдаг	0 (0%)	0 (0%)	2 (18%)	5 (45%)	4 (36%)	45%
4	ХАБЭА төгсөгчид бодлого, хөтөлбөр боловсруулагч, төлөвлөгч байж чаддаг	0 (0%)	1 (9%)	3(27%)	4 (36%)	3 (27%)	36%
5	ХАБЭА төгсөгчид үр ашигтай хамтрагч, харилцагч байдаг	0 (0%)	0 (0%)	3 (27%)	6 (54%)	2 (18%)	55%
6	ХАБЭА төгсөгчид соёл ёс зүйг эрхэмлэгч байдаг	0 (0%)	0 (0%)	1 (9%)	6 (54%)	4 (36%)	55%
7	ХАБЭА төгсөгчид нь олон нийтийн ажилтан нөлөөлөгч байдаг	0 (0%)	0 (0%)	2 (18%)	6 (54%)	3 (27%)	55%
8	ХАБЭА төгсөгчид нь санхүүч, удирдагч байдаг	0 (0%)	1 (9%)	2 (18%)	6 (54%)	2 (18%)	55%
9	ХАБЭА төгсөгчид нь манлайлагч байдаг	0 (0%)	0 (0%)	1 (9%)	8 (72%)	2 (18%)	73%
	Дундаж утга	0	0.2	2.3	5.6	2.9	51%

Хэлцэмж: Судлаач Д.Отгонбаяр нарын (2010) оны "Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ" нэг сэдэвт бүтээлдээ анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдын сэтгэл ханамжийн түвшинг Ликертийн хэмжүүрээр тодорхойлоход дундаж утга 3.41 гэсэн үнэлгээ өгсөн байна.[4] Бидний судалгаагаар ХАБЭА-н хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдын сэтгэл ханамжийн түвшинг Ликертийн хэмжүүрээр тодорхойлоход дундаж утга 3.7 гэсэн үнэлгээтэй өгсөн нь ХАБЭА-н мэргэжлээр суралцагсад хөтөлбөртөө сэтгэл хангалуун байгааг илтгэж байна.

Судлаач Анита К (2022) нарын "Оюутны сэтгэл ханамжийн судалгаа"-ны үр дүнгээс харахад багш нарын хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үр дүнтэй байдал, хүртээмжтэй байдал, ур чадвар, мэдлэг олгох чадвар, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, шалгалтын шударга байдал зэрэгт үндэслэн харахад нийт оюутнууд 3.59 сайн хэмээн үнэлгээ өгсөн байна. Бидний хийсэн судалгаагаар сургалтын хөтөлбөрт сэтгэл ханамжийн судалгааг тодорхойлсон суралцагчид багшийн заах арга зүйд 3.9 оноо, суурь сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадварыг бодитой шударга үнэлсэн байдалд 3.7 оноогоор сэтгэл ханамжийг үнэлсэн байгаа нь ХАБЭА хөтөлбөрт сэтгэл ханамжийн түвшин дунджаас дээш үзүүлэлттэй байна.

Дүгнэлт: Суралцаж буй оюутан, төгсөгч, ажил олгогч нарын ХАБЭА бакалаврын сургалтын хөтөлбөрт өгсөн сэтгэл ханамжийг тодорхойлсон дүнгээс харахад уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалттай төдийгүй сэтгэл ханамжтайг байгаа нь тодорхойлогдлоо.

Талархал: Энэхүү судалгааны ажлыг хийхэд гүн туслалцаа үзүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжиж ажилласан АШУҮИС-ийн Нийгмийн Эрүүл мэндийн сургуулийн багш нар болон судалгаанд хамрагдсан АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй мэргэжлээр суралцаж буй оюутан, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ХАБЭА-н ажилтнуудад талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Д.Нарансүх Монгол улсын Хөдөлмөрийн эрүүл мэндийн төлөв байдал УБ. 2019 он, х5-7*
2. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 2021 он шинэчлэгдсэн хувилбар УБ. 2022 он (2022.03.22).*
3. *Б.Уртнасан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны төлөв байдлыг судалсан дүн" Нийгмийн эрүүл мэндийн магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2017 он, х7-9*
4. *Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212, УБ. (2021.03.28)*
5. *Д.Отгонбаяр «Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд" Анагаах ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2010 он, х29-39*
6. *Mahad Khalif Dhaqane Master of MBA, Nor Abdulle Afrah Master of MBA, Satisfaction of Students and Academic Performance in Benadir University, 2016, Pages 4 https://files.eric.ed.gov/fulltext/EJ1112855.pdf*
7. *Anita Kanwar & Meghana Sanjeeva Student satisfaction survey: a key for quality improvement in the higher education institution-2022. Pages 8, https://innovation-entrepreneurship.springeropen.com/articles/10.1186/s13731-022-00196-6*
8. *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтний өөрийн үнэлгээний тайлан. УБ. 2022 он, х11-17*
9. *Н.Сүмбэрзул, Ш.Оюунбилэг Анагаах Ухааны боловсрол. Улаанбаатар. 2001 он, х27-32*

The evaluation of the bachelor's program in occuptional safety and health

Khaliunaa G[1], Nansalmaa N[1], Enkhdulguun A[2], Erdenechimeg E[1], Munkhzaya M[3]

[1]Department of the Enivornmental healt, School of Public Health, MNUMS
[2]The Department of Preventive Medicine, School of Public Health, MNUMS
[3]Department of the Nutrilogy, School of Public Health, MNUMS
E-mail: eph22e002@gt.mnums.edu.mn, Tel: +976-86007691

Background: In recent years, with the increase in industrialization in Mongolia, there is a growing need for specialists who aim to protect the health and safety of employees from accidents and occupational diseases caused by dangerous workplace factors. As of 2020, the number of industrial accidents in Mongolia has increased by 0.5 percent to 353. Related to this is the issue of professional human resources to provide health and safety care services for workers.
Aim: To evaluate the satisfaction of students, graduates and employers of occupational safety and health training.
Materials and Methods: 1st-4th year 35 students studying in the Bachelor's program of Occupational safety and health at School of Public Health of the MNUMS, 11 graduates and 12 executives who graduated from the 2021 Bachelor's program of Occupational safety and health at School of Public Health of the MNUMS were included in the research. A Likert scale was used to evaluate satisfaction in the survey. Data was entered into the Microsoft Office Excel, converted into the SPSS 22.0 software, and a detailed statistical analysis was performed.
Results: In order to evaluate the learning environment, quality, and satisfaction, 35 (87.5%) who are studying HSE for more than 1 semester, or 28.5% (n=10) of the 1st course, 11.4% (n=4) of the 2nd course, 5.7% (n=2) of 3rd year students and 54.2% (n=19) of 4th year students were included. When studying the satisfaction of students studying in the HSE program, the courses that gave the most points were 4.21 points for complete mastery of the content, 4.09 points for the teacher's methodology, realistic student evaluation methods, good condition of the learning environment (rooms, laboratories, equipment) 3.87 points, and whether the lesson was a preparation for the next lesson was evaluated with 4.19 points. According to the results of the study on the satisfaction of HSE graduates with the educational activities, the rating given to the appropriateness of the student's learning load was 4.63 points, the teachers' teaching methods were good or 4.36 points, and the knowledge and skills acquired through training were evaluated objectively and fairly, 4.09 points. 4.09 points for good training organization and 4 points for effective training were rated above average or close to good.
Conclusions: Based on the results of the satisfaction of students, graduates, and employers with the HSE bachelor's training program, they concluded that the implementation of the program is satisfactory.

Keywords: Graduate skills, Training, Satisfaction, Student and knowledge